



ХОГГҮЙ АРГА ХЭМЖЭЭ

ӨДӨРЛӨГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА, БАЯР ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАРЫН АВЛАГА

Энэхүү гарын авлагыг Европын Холбооны SWITCH Asia-II хөтөлбөрөөс санхүүжүүлэн хэрэгжүүлж буй “Монгол улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах” төслийн хүрээнд Монголын Тогтвортой Хөгжлийн Гүүр ТББ бэлтгэв. Тус хэвлэмэлийн агуулга нь Европын Холбооны байр суурийг илэрхийлээгүй болно.

АГУУЛГА

01. ХОГГҮЙ АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ 10 ШАЛТГААН

02. АРГА ХЭМЖЭЭНИЙ УРЬТАЛ ТӨЛӨВЛӨГӨӨ

2.1 Арга хэмжээнийхээ маркетинг, сурталчилгааг хийх

2.2 Урилга ба хаалганы бэлэг

2.3 Хоол хүнс, ундаа

2.4 Ажилтнууд ба сайн дурынхан

03. АРГА ХЭМЖЭЭ ҮРГЭЛЖЛЭХ ҮЕИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3.1 Хогийн сав бэлдэх

3.2 Ангилах зааврыг мэдээлэх, хяналт хийх

3.3 Хог хаягдал, дахиврыг цуглуулах

04. АРГА ХЭМЖЭЭНИЙ ДАРААХ ҮЕИЙН ТӨЛӨВЛӨЛӨГӨӨ

4.1 Үнэлгээ гаргах

4.2 Арга хэмжээний дараах сурталчилгаа

05. ХОГ ХАЯГДЛЫГ АНГИЛАХ ЗААВАРЧИЛГАА

БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ БҮТЭЭГДЭХҮҮН ХУДАЛДААЛДАГ ДЭЛГҮҮРҮҮД

ДАХИВАР ТУШААХ БАЙРШЛУУД БОЛОН ХОЛБОО БАРИХ МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛС ДАХЬ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРҮҮД

**ЗАРИМ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД, ОЛОН НИЙТИЙН БҮЛГҮҮДИЙН
СОШИАЛ ХОЛБООСУУД**

1



ХОГГУЙ АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ

10 ШАЛТГААН

ХОГ ХАЯГДЛАА АНГИЛАН ЯЛГАХ НЬ БАЙГАЛЬ ОРЧИН, ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМД ТАНЫ ТӨСӨӨЛСНӨӨС Ч ИЛҮҮ ЭЭРЭГ НӨЛӨӨГ БИЙ БОЛГОДОГ.

01



ХОГНЫ ХЭМЖЭЭ БУУРНА

Арга хэмжээ зохион байгуулахад цаас, ус, нэг удаагийн аяга гэх мэт маш их хог хаягдал гардаг ба судалгаагаар нэг оролцогчид ноогдох хаягдлын хэмжээ ойролцоогоор 1.85 кг байдаг нь МУ-ын нэг өрхийн өдрийн хог хаягдлаас 3 дахин өндөр байна. Хог хаягдлыг хогийн цэг рүү явуулахгүй байх нь хоггүй арга хэмжээний гол зорилго юм.

ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫГ БУУРУУЛНА

Хог хаягдалгүй арга хэмжээ нь байгалийн нөөцийг олборлох, ашиглах, хэрэглэхтэй холбоотой хүлэмжийн хийн ялгарлыг бууруулаад зогсохгүй хог хаягдлаас үүсэх метан болон бусад хоруу хийг үүсгэхээс зайлсхийж буй чухал үйлдэл юм

02



ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭНЭ

Хоггүй арга хэмжээ нь савлагаа бүрт зарцуулагдах эрчим хүчийг хэмнэх бөгөөд зайлшгүй тохиолдолд савлагааг хэрэглэх бол дахин боловсруулах боломжоор хангах чухал юм. Зөвхөн нэг кг ундааны савыг дахин боловсруулснаар 13W-ын чийдэнг 20 хоног тасралтгүй асаах эрчим хүчийг хэмнэдэг байна

03



БАЙГАЛИЙН ХЯЗГААРЛАГДМАЛ НӨӨЦИЙГ ХЭМНЭНЭ

Байгалиас олборлож буй бүх төрлийн ашигт малтмал, газрын ба ойн баялаг, түүхий эдийг хэмнэхээс гадна ус, ургамал, амьтад, хуурай газрын ашиглалтыг бууруулдаг.

04



05



ЭДИЙН ЗАСГИЙН ХЭМНЭЛТИЙГ БИЙ БОЛГОНО

Хог хаягдалгүй систем нь хэрэгцээгүй худалдан авалтыг бууруулж, эдийн засгийн хэмнэлтийг бий болгодог.

ОЛОН ТӨРЛИЙН ӨВЧНӨӨС СЭРГИЙЛНЭ

Хог хаягдлаас ялгарах хортой бодисууд амьсгалын зам, зүрх судас, хоол боловсруулах эрхтэн, харшил болон архаг хууч өвчлөлүүдийг үүсгэх эрсдэлтэй байдаг. Хог хаягдал нийгмийн сэтгэл зүйд ч сөргөөр нөлөөлдөг.

06



ЭКОЛОГИЙН УЛ МӨРИЙГ БУУРУУЛНА

Дэлхийн нэг хүний экологийн ул мөр 1,6 гга дотроо байвал дэлхийн даацын хүрээнд байна гэж тооцох боловч Монгол хүний экологийн ул мөр 7,3 гга хэмжээтэй байна гэсэн тооцоо гарчээ. Хог хаягдалгүй байх нь таны экологийн ул мөрийг бууруулхад тустай.

07



АГААР, ХӨРС, УСНЫ БОХИРДЛООС СЭРГИЙЛНЭ

Зарим хог байгальд задартлаа хөрс, ус, агаарт сөрөг нөлөөллийг байнга үзүүлдэг бөгөөд он удаан жил байгальд оршоор байдаг. Хуванцар нь цаг хугацаа өнгөрөх тусам бичил, нано хэсгүүд болон задрах боловч байгальд огт шингэдэггүй.

08



10



БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛНА

Бидний үлдээсэн хог хаягдал байгалийн олон янз байдалд маш сөрөг нөлөөтэй бөгөөд зарим тохиолдолд үхлийн аюул ч дагуулдаг. Бусад амьтад, ургамал зэрэг амьд биесд хохирол учруулахгүйн тулд зохион байгуулж буй арга хэмжээгээ хоггүй байлгаарай.

ИРЭЭДҮЙ ХОЙЧДОО БАЯЛАГ ӨВИЙГ ҮЛДЭЭНЭ

Хог хаягдалгүй арга хэмжээ зохион байгуулах нь байгаль орчноо хамгаалж, ирээдүй хойчдоо үлдээх хамгийн том өв баялаг болно.

10



2

АРГА ХЭМЖЭЭНИЙ УРЬТАЛ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдалгүй байх шалтгааныг бодит дүр зургаар ойлгож, хоггүй арга хэмжээнд хүчин чармайлт гаргахдаа баг хамт олноороо мэдлэг, мэдээлэлтэй байх хэрэгтэй.

2.1 АРГА ХЭМЖЭЭНИЙ СУРТАЛЧИЛГАА



Оролцогчдод хог хаягдалгүй байх мэдээллийг хүргэхийн тулд нүүр тулсан, бичгээр эсвэл дижитал хэлбэрээр бүх харилцаа холбооны явцад хог хаягдалгүй арга хэмжээний зорилгыг онцлон сурталчлах шаардлагатай.

Хог хаягдалгүй бүх арга хэмжээнд ЗАЙЛШГҮЙ БАЙХ зүйлсийн жагсаалтад дараах зүйлс орно:



**ДАХИН АШИГЛАХ
БОЛОМЖТОЙ
ХУДАЛДААНЫ УУТ**



**ОЛОН УДАА АШИГЛАХ
САВЛАГААНУУД**



**УСНЫ
САВ**



УХААЛАГ УТАС

нэрийн хуудас тараахын
оронд нэрийн хуудасны
зургийг авах



**ХООЛНЫ САВ,
ХУТГАНЫ ХЭРЭГСЭЛ**

хэрэв хоол хүнс, хоол
хүнстэй холбоотой бол



АЛЧУУР

салфетка орлуулах



Арга хэмжээг олон хүнд хурдан хургэж сурталчлан таниулах зорилгоор олон нийтийн сүлжээг ашиглах боломжтой. Бүх оролцогчид, ажилчид, сайн дурынханд үйл ажиллагаанаас өмнө шаардагдах зүйлс:



**ЦАХИМ ХЭРЭГЛЭЭ РҮҮ
ШИЛЖИХ**



**ВЭБ САЙТ РҮҮ ХЯЛБАР
НЭВТРЭХ ВІТ.ІУ
ХОЛБООСУУД ҮҮСГЭХ**



**УХААЛАГ УТСААР
ХЯЛБАР НЭВТРЭХ QR
КОД ҮҮСГЭХ**



**ОНЛАЙНААР
МЭДЭЭЛЛЭЭ
ХУВААЛЦАХ**



Дээрх аргуудыг хэрэглэх боломжгүй бол уламжлалт маркетинг, сурталчилгаа болон оролцогчдын холбоосыг дараах хэлбэрээр хог хаягдал багатай байхаар шийдвэрлээрэй.



**АШИГЛАСАН ЦААСАН
ДЭЭР ХЭВЛЭХ**



**ЖИЖИГ ФОНТ
АШИГЛАХ**



**ЦААСНЫ ХОЁР ТАЛД
ХЭВЛЭХ**



**НЭГ ХУУДСАНД АЛЬ
БОЛОХ ОЛОН СЛАЙД
ХЭВЛЭХ**

2.2 УРИЛГА



Үйл ажиллагааны зохион байгуулалтын өмнөх хог хаягдлыг бууруулахын тулд онлайн болон имэйл ашиглан урилга, тасалбараа илгээж мөн хариуг цахим систем ашиглан бүртгээрэй. Дээр дурдсан хог хаягдалгүй арга хэмжээнд ирэхдээ заавал авчрах ёстой зүйлсийг урилган дээр онцлон тэмдэглэж болно. Урилгад уг арга хэмжээ нь хог хаягдалгүй

болно гэдгийг дурдаарай. Мөн урилга илгээсний дараагаар хариу өгөх (RSVP) тодорхой хугацаа өгч, нийт оролцогчдын тоог тооцоолж хоол, ундны хаягдлаас сэргийлж оролцогчдын тоонд тааруулж бэлтгэнэ. Үлдэгдэл хоолыг гэрлүүгээ авч явахыг уриалж өөрийн хоолны саваа авчрахыг сануулаарай.

2.3 ХООЛ ХҮНС



Хоол хүнсийг зөвхөн идэх, байгальд ээлтэйгээр ангилан хаях бус хог хаягдалыг бууруулах аргаар хоолоо бэлтгэхийг санал болгож байна. Жишээлбэл, хоол хүнсийг бэлтгэж буй газраас хоол хийхэд ашиглагдаг тос, нүүрсийг дахин боловсруулах хүсэлт тавьж болно.



Кофе, цайгаар үйлчилж байгаа тохиолдолд хог хаягдалаа бууруула



Халбага, хутга, сэрээ зэрэг хэрэгслүүд шаардахгүй жижиг хэмжээтэй (bite-size, finger food) хоолны сонголтуудийг хийгээрэй. Буфет маягийн хоолоор үйлчлэх гэж байгаа бол оролцогчдод хүнсний хаягдал гаргахгүй байх сануулгыг найрсагаар сануулаарай.



Мах, сүүн бүтээгдэхүүн мөн тослог хүнсний бүтээгдэхүүнүүд нь бусад хүнсний бүтээгдэхүүнтэй харьцуулбал бордоо болж задрахдаа илүү удаан ба байгаль орчинд илүү их хор хөнөөл учруулдаг тул хоол хүнсийг хариуцаж буй газраас мах, сүүн бүтээгдэхүүн, тослог хоолыг бага байхыг үйлчлэхийг хүсээрэй. Мөн аль болох орон нутгийн, органик, байгальд ээлтэй хүнс хэрэглэхийг уриалж болно.



Байгаль орчинд экологийн ул мөр багатай, дэлхийн дулаарлын сөрөг нөлөөллийг бууруулахад веган буюу амьтны орцгүй хоол хүнсийг байгаль хамгаалагчид, уур амьсгалын эрдэмтэд хэрэглэхийг зөвлөж байна. Сүүлийн үед ийм хоолтон хүмүүсийн тоо эрс олширч байгаа учраас тэдэнд мөн сонголттой байх боломжоор хангаж веган хоолны сонголтыг бэлдээрэй. Ургамлын гаралтай уураг үйлдвэрлэх нь ердийн мах үйлдвэрлэхээс 90% хүртэл бага хүлэмжийн хий ялгаруулдаг. Хүнсний гаралтай хүлэмжийн хийн ялгарлын 14.5%-ийг мах, сүүн бүтээгдэхүүн эзэлдэг байна.

ХООЛНЫ САВЛАГАА

Нэг удаагийн хоол, ундны савлагаа, халба сэрээ зэрэг хэрэглээ нь байгальд хурдан задардаггүй, Монгол улсад дахин боловсруулагддаггүй тул зохиож буй арга хэмжээ нэг удаагийн хэрэглээнээс зайлсхийвэл сайн. Хэрэв шаардлагатай бол байгалийн гаралтай, хурдан задардаг савнуудыг сонгоорой. Анхдагч мод ашиглаж үйлдвэрлэсэн нэг удаагийн хоолны савнууд байгалийн нөөц ашиглалтад сөрөг нөлөөтэй учир түргэн нөхөн сэргээгддэг хулс эсвэл тарианы ишний хаягдлаар хийсэн савлагаанууд зах зээл дээр борлуулагдаж байна.



БОРДОО БОЛДОГ БОРДУ САВ: эрдэнэ шишийн шавхдас болон хулсаар хийгдсэн хоолны нэг удаагийн савлагаанууд бөгөөд 30-90 хоногийн дотор био задралд ордог. Задралд орохдоо байгалийн, органик,

нөхөн сэргээгдэх материалаар хийгдсэн тул байгальд байгалийн орц найрлагыг буцаан шингээж өгдөг.



2.4 АЖИЛТНУУД БА САЙН ДУРЫНХАН



Хог хаягдалгүй үйл ажиллагааг амжилттай явуулахад сайн дурынхан гол үүрэг гүйцэтгэдэг. Хог хаягдал ангилах цэг бүрт анхан шатны хог хаягдал ангилах тухай асуултуудад хариулж, хог хаягдалгүй байдлын талаарх асуултуудад хариулах чадвар олгох сургалтанд хамрагдсан сайн дурын ажилтан байх

хэрэгтэй бөгөөд тэдгээр нь оролцогчдод тусалж, хогийн савны хооронд бохирдол үүсгэхгүй, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхэд тусална.



Зохиох арга хэмжээнд хичнээн сайн дурын ажилтан хэрэгтэйг тодорхойлохын тулд зохион байгуулах талбайн газрын зургийг ашиглан хаана, хэзээ (үйл явдлын өмнөх, үеэр болон дараа) сайн дурынхныг томилох шаардлагатайг тодорхойлоорой.



Үйл ажиллагааг илүү үр бүтээлтэй болгох үүднээс сайн дурын ажилтны үүрэг, цагийн хуваарийг урьдчилан хуваарилахыг зөвлөж байна.

ХОГ ХАЯГДАЛГҮЙ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГИЙГ СОНГОСНООР БАЙГАЛЬ ОРЧИНДОО ЭЭЛТЭЙГЭЭС ГАДНА БҮТЭЭЛЧ ЧАДВАРАА ХӨГЖҮҮЛЭХ ТОМ БОЛОМЖИЙГ ОЛГОДОГ

Ямар нэгэн арга хэмжээ, хурал, уулзалт, баярт үйл явдлуудыг зохион байгуулахад хог хаягдлын хэмжээ эрс нэмэгддэг бөгөөд оролцож буй хүний тоогоор үржигдэж байдаг.

Хоггүй буюу тэг хаягдал гэдэг нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй бүтээгдэхүүн, сав баглаа боодлыг хөрс, ус, агаарт хаяхгүйгээр мөн шатаалгүйгээр, хариуцлагатай үйлдвэрлэх, хэрэглэх, дахин ашиглах, нөхөн сэргээх замаар бүх нөөцийг хэмнэхийг хэлнэ.

Хог хаягдлаа багасгах, дахин боловсруулах, зөв зохистой устгах боловсронгуй шийдлийг олох гэж дэлхий нийтээрээ тэмцсээр байгаа үед Монголын Тогтвортой Хөгжлийн Гүүр нь Монгол хүн бүрийг үүнд хувь нэмэрээ оруулж, өөрчлөлт хийхийг уриалж байна.

З

АРГА ХЭМЖЭЭ ҮРГЭЛЖЛЭХ ҮЕИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3.1 ХОГИЙН САВ БЭЛДЭХ



Үүсэх боломжтой хог хаягдлаас сэргийлж хаягдал ангилах цэгүүдийг тодорхойлох хэрэгтэй ба арга хэмжээнд оролцож буй хүн бүрт хог ангилах цэгүүд хүртээмжтэй, ангилахад хялбар байлгах нь чухал. Ангилах цэгүүдийг орц, гарц, хоолны газар гэх мэт хог хамгийн ихээр үүсч болзошгүй газруудад байрлуулах шаардлагатай

- Тэмдэглэгээ, зааварчилгааны самбар байрлуулах: хог хаягдал ангилах цэгийн тэмдэглэгээ, зааварчилгаа нь арга хэмжээнд оролцогчдод хурдан бөгөөд зөв ангилахад тусална. Тэмдэглэгээ нь маш энгийн байх ёстой бөгөөд арга хэмжээ зохион байгуулагдах газар даяар бүгд жигд ижилхэн байх хэрэгтэй.
- Хог хаягдал ангилах цэгүүдийг газрын зурагт заасан зөв газруудад байрлуулж бүх хогийн савнуудын дараалал, тэмдэглэгээг зөв байршуулах.
- Хог ангилах цэгүүд бүрт нэмэлт хогны уут, бээлий зэрэг шаардлагатай материалаар хангах.
- Арга хэмжээнд зориулагдаагүй бусад хогийн савнуудыг үйл ажиллагаа дуустал өөр газар байршуулах

3.2 АНГИЛАХ ЗААВРЫГ МЭДЭЭЛЭХ, ХЯНАЛТ ХИЙХ



Арга хэмжээний эхэнд хог хаягдалгүй байх ач холбогдлын тухай танилцуулаарай. Уг арга хэмжээнд оролцогчдод ямар хаягдлыг дахин боловсруулах эсвэл ямар хаягдлаар компост бордоо хийх боломжтойг товч тайлбарлаж болно. Хог хаягдал ангилах цэгүүдийн байршлуудыг зааж оролцогчдоос хоггүй арга хэмжээний талаарх эргэлзэж буй зүйл байгаа эсэхийг лавлаж асуугаарай.



Оролцогчид хаягдлаа зөв ангилж байгаа эсэхийг байнга шалгах шаардлагатай. Цэг бүрт харгалзах сайн дурын ажилтан байгаа эсэхийг шалгаж, дүүрсэн хогийн уутнуудыг тогтмол солих шаардлага тавиарай.

3.3 ХОГ ХАЯГДАЛ, ДАХИВРЫГ ЦУГЛУУЛАХ



Арга хэмжээний төгсгөлд эцсийн цэвэрлэгээ: бүх хогийн савнуудад хаягдал зөв ангилагдсаныг шалгаж, дахиврууд болон бусад хогнуудыг цуглуулна. Эцсийн хэмжилт хийж бүгдийг жинлэж, ангилал бүрт хэр хэмжээний дахивар, хог хаягдал цугларсаныг тодорхойлно

4

АРГА ХЭМЖЭЭНИЙ ДАРААХ ҮЕИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1 ҮНЭЛГЭЭ ГАРГАХ



Үнэлгээг арга хэмжээний эцсийн ангилсан дахивар ба хог хаягдлын үнэлгээ мөн хамтран ажилласан хүмүүс болон оролцогчдоос сэтгэгдэл болон санал хүсэлт авах хоёр хэлбэрээр гаргана.



Төрлөөр нь ангилж жинлэсэн хог хаягдал ба дахиврын мэдээлэл нь хүлэмжийн хийн ялгарлын нөлөөлөл болоод бусад үр дүнг гаргахад чухал. Мөн нийт ангилсан дахиврын хэмжээг арга хэмжээний эцэст нийт оролцогчиддоо мэдээлэх нь цаашдын энэ үйл ажиллагааг дэмжих нөлөөллийг ойлгуулахад тус болгоно.



Оролцогчдоос уг үйл ажиллагаа хэрхэн нөлөөлсөн эсэх, үүгээр юу сурч олж мэдсэн, мөн давуу тал ба сул тал байсан талаар мэдэх хэрэгтэй. Үнэлгээ гаргаснаар хэрхэн дараа дараагийн арга хэмжээнүүдийг сайжруулж илүү үр дүнтэй болох боломжтойг тодорхойлно.



Хог хаягдалгүй арга хэмжээний туршлагаа бусдад хуваалцаарай. Нийгэмд зохион байгуулсан арга хэмжээний мэдээлэл, сурталчилгаа түгээснээр хоггүй үйл ажиллагаа зохион байгуулах боломжийг харуулж бусдад үлгэрлэн уриалан дуудах юм. Үүнд:

- Хог хаягдалгүй арга хэмжээний амжилтаа хуваалцах, амжилтаа тодорхойлох,
- Ирээдүйд зохион байгуулагдах хог хаягдалгүй арга хэмжээнд өгөх зөвлөмж, сайжруулах боломжийг харуулах,
- Тайлан, мэдээллийн товхимолоор хийсэн ажиглалт, туршлагаа түгээх зэрэг багтана.



Хамтран ажилласан байгууллага, хүмүүс болон оролцогчиддоо талархал илэрхийлэн арга хэмжээний дараах үнэлгээ, үр дүнг хуваалцаарай. Эцэст нь дараагийн арга хэмжээгээ хог хаягдалгүйгээр зохион байгуулахыг санал болгоорой.

БУСАД АНХААРАХ ЗҮЙЛС: БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ БЭЛГИЙН БАГЛАА БООДОЛ

Тэмдэглэлт баяр, арга хэмжээний үеэр бэлгийн баглааны цаасны эрэлт нэмэгддэг. Гэвч дийлэнх савлагаа, баглааны цаасыг дахин боловсруулдаггүй бөгөөд ихэнх нь хогийн цэгт хаягддаг. Зөвхөн бэлгийн баглаа боодлын цаас үйлдвэрлэхийн тулд жил бүр 50 мянга орчим мод тайрдаг гэсэн тооцоо бий. Хэрэв бүх бэлгийн баглааны цаасны хаягдлыг дахин боловсруулбал шинээр цаас үйлдвэрлэхээс 70% бага эрчим хүч шаардагдана. Зөвхөн нэг тонн дахин боловсруулсан бэлгийн баглааны цаас нь 17 мод, хогийн цэгийн 18.7 метр квадрат талбай, 4000 киловатт эрчим хүчийг хэмнэх боломжтой. Шинэлэг бөгөөд байгальд ээлтэй бэлгийн баглааны дараах санаануудыг туршаад үзээрэй:



КРАФТ ЦААС: Байгальд задардаг, дахин боловсруулах боломжтой бор цаасыг сонгох нь гялалзсан, ламинат хийгдсэн, гялгар бүрэлттэй цааснаас татгалзах нэг арга юм. Мөн энэ нь таны бэлгийг минимал бөгөөд тансаг харагдуулах болно.



ЦАГААН ХЭРЭГЛЭЛ: хуучин ор хөнжлийн даавуунуудаа хаялгүйгээр бэлэг баглахад ашиглаж болно.



ХУУЧИН БАГЛАА БООДОЛ: хэрэвээ та багласан бэлэг бэлгэнд авсан бол баглааны цаасыг хаялгүйгээр ахин бэлэг баглахад ашиглах боломжтой.



СОНИН, СЭТГҮҮЛ: гэрт тань хуучин сонин, сэтгүүл цугларсан байвал бэлэг баглахад ашиглаж илүү хуучны өнгө аяс оруулаарай.



ГУТЛЫН ХАЙРЦАГ: айл бүрт байдаг гутлын цаасан хайрцгийг крафт цаасаар бүрж бэлгийн хайрцаг болгон ашиглаж болно.




БАЙГАЛИЙН ГАРАЛТАЙ ЧИМЭГЛЭЛИЙН ЭЛЕМЕНТҮҮД: нэг удаа хэглээд хаягдах тууз, скоч, стикер зэргийг ашиглахаас татгалзаж хатаасан цэцэг, навч, модны мөчир, боргоцойг чимэглэл болгон хэрэглээрэй.



БАЙГАЛЬД ЗАДАРДАГ СКОЧ: уламжлалт пластик скочны оронд байгальд задардаг скочийг ашиглан бэлгээ баглаарай

ХОГГҮЙ БАЙХ НЬ ТӨСӨӨЛСНӨӨС Ч ХЯЛБАР ЮМ

Арга хэмжээгээ хог хаягдалгүй зохион байгуулах нь хог хаягдалгүй байх боломжит загварыг бий болгохын зэрэгцээ ирэх зочиддоо байгаль орчинд ээлтэй гэдгээ харуулах боломж байж болох юм. Арга хэмжээний зорилго, том жижиг цар хүрээнээс үл хамааран ашиглаж болох бүх зүйлсийг дахин ашиглах, дахин боловсруулах эсвэл бордоо болгох боломжтой байдлаар сайтар төлөвлөх нь хог хаягдалгүй арга хэмжээ зохион байгуулах гол түлхүүр юм.



5

ХОГ ХАЯГДАЛ АН ЗААВАРЧ

ХУВАНЦАР

Бүх төрлийн ундааны сав, нэг удаагийн зөөлөн хуванцар халбага сэрээ, саван шампуный сав, сүү тараг, талх, нарийн боовны зөөлөн гялгар уут, хүнсний скоч, /PET, HDPE, PVC, LDPE, PS/, Styrofoam хөөсөнцөр

Анхаарах зүйлс:

- Уут, савлагааны овор хэмжээг багасгах
- Цэвэрхэн байх.

PET

- Ус ундаа
- гоо сайхны бүтээгдэхүүн
- эм, витамин
- бусад ♻️PET гэсэн тэмдэгтэй хатуу хуванцар савлагаанууд

HDPE


- Цэвэрлэгээний бүтээгдэхүүн
- Гоо сайхны бүтээгдэхүүн
- Бусад ♻️HDPE гэсэн тэмдэгтэй хатуу хуванцар савлагаанууд

LDPE

- Сунаж урагддаг гялгар уутнууд
- гоо сайхны бүтээгдэхүүний ♻️LDPE гэсэн тэмдэгтэй уян савлагаанууд

PP

- Нэг удаагийн хоолны сав, аяга, халбага, сэрээ, соруул
- PP толгоомууд
- Тараг майонезны савлагаа




ЦААС

Бичгийн, дэвтрийн, сонингийн болон бусад төрлийн хаягдал цаас, бор цаас, картон, өндөгний сав.

Анхаарах зүйлс:

- Шохойгүй байх
- Үдээсгүй байх
- Наалтгүй байх (скочгүй)



АНГИЛАХ ШИЛГЭЭ

Дахин боловсруулах үйлдвэр нь хог хаягдлыг нарийн ангилахыг шаарддаг боловч хоёрдогч түүхий эд болох боломжтой хог хаягдлыг орон сууц болон гэр хорооллын айл өрх үүсгэж буй хогны төрлүүдээсээ шалтгаалан дараах үндсэн ангиллуудаар хогийг ангилан ялгана.

ШИЛ/ЛААЗ

Хөнгөн цагаан ундаа, пивоны лааз, бүх төрлийн цонхны шил, толь, хүнсний бүтээгдэхүүн, архи пиво, ундааны шил

Анхаарах зүйлс:

- Цэвэрхэн байх
- Лаазны овор хэмжээг багасгах



ҮНС, ШААРГА

Үнсийг тусд нь хадгалснаар дахин ашиглаж, түүхий эдийн нөөц болгох боломжтой юм.



ХҮНСНИЙ ХАЯГДАЛ

Дахин боловсруулалтанд хүнсний хаягдлыг цуглуулж тээвэрлэх нь өрхийн хэмжээнд хараахан шийдэгдээгүй байгаа ч хүнсний хаягдлаараа өөрсдөө ялзмаг бордоо хийж болно.



ЖИЖИГ ЗАЙ ХУРААГУУР

Жижиг зай хураагуурыг та гэртээ цуглуулж байгаад И-март болон СУ сүлжээ дэлгүүрүүдэд аваачиж тусгай зориулалтын хогийн саванд хийгээрэй. Эдгээр нь дахин боловсруулагдахгүй ч түр хадгалах тусгай саванд байршуулах ёстой аюултай хог хаягдал юм.



ДАХИН БОЛОВСРУУЛАГДАХ БОЛОМЖГҮЙ ХОГ ХАЯГДАЛ

ЦААС Шохойтой буюу гялгар бүрэлттэй, тос болж бохирдсон цаас.

ХУВАНЦАР Манай улсад дахин боловсруулах боломжгүй хуванцар савлагаанууд: зиплок уут, чихэр, чипсний уут г.м.

ШИЛ Автомашины хагарсан шил

ДАХИВАР ТУШААХ БАЙРШЛУУД, ХАЯГ, ХОЛБООСУУД

ДҮҮРЭГ	ХАЯГ	УТАС
СХД	СХД 5-р хороо Баянгол 13-1	99725888
	СХД 5-р хороо Баянгол 46-4Б	99080378
	СХД 6-р хороо Тоосго 12-1Д	99741448
	СХД 26-р хороо Мандал Овоо 19-41	99036138
	СХД 26-р хороо Мандал Овоо 19-43	99227856, 99036590
	СХД 30-р хороо Чулуут 6-3	80936767, 95826767
	СХД 18-р хороо Мандал Овоо 18-55	99991712, 99998407, 95956336, 80117336
	СХД 26-р хороо Алтан Овоо 30-29	96066929
	СХД 26-р хороо	80050972, 89190818
	СХД 23-р хороо Хангай 27-1	88647873, 99987873
	СХД 9-р хороо Уулын гудамж	99520371
	СХД 4-р хороо Их Наран 4-1	91187062, 99775300
	СХД 4-р хороо Их Наран 3-1	88925594
	СХД 24-р хороо Зээл 27-37А	99746589, 99740840
	СХД 10-р хороо Баян-Уул 11-2	96211015
	СХД 34-р хороо Хилчин 52-8	88911002
	СХД 42-р хороо Орбит 24-7	96350930
	СХД 7-р хороо	99933596
СХД 20-р хороо	98183218	
БЗД	БЗД 2-р хороо 12-10-91	96685858, 96861718, 77750058
	БЗД 14-р хороо	88704841
	БЗД 9-р хороо Шар Хад 29-459	99116567, 95072515
	БЗД 22-р хороо 36-673	99039158
	БЗД 22-р хороо 12-293	88005783, 88116196
	БЗД 22-р хороо 9-256	88558287, 89095855
	БЗД 11-р хороо Товчоо 1-14	99087007, 88087007, 96666025
	БЗД 28-р хороо Хужирбулан 1-15	88639475, 88708885

ДАХИВАР ТУШААХ БАЙРШЛУУД, ХАЯГ, ХОЛБООСУУД

ДҮҮРЭГ	ХАЯГ	УТАС
БЗД	БЗД 28-р хороо Хужирбулан	80116047, 99311204
	БЗД 17-р хороо Да Хүрээ Зах	99651016
	БЗД 11-р хороо Ногоон Зоорь Амгалан	95159020
	БЗД 14-р хороо Нарантуул Зах	96548101, 95191001
	БЗД 8-р хороо Эрдэнэтолгой 48-216	99263090
	БЗД 22-р хороо 32-531	99054543
	БЗД 2-р хороо 4-208	89192632
	БЗД 2-р хороо Сэлбэ 10-91	88130083
	БЗД 11-р хороо	99659779
	БЗД 19-р хороо Цайз 4Б-3	88801578
БГД	БГД 21-р хороо 16-384	96353060
ЧД	ЧД 7-р хороо Хувьсгалчид 12-196	99662670, 95954562
	ЧД 1-р хороо Нуур 21-465	88709002, 86960399
	ЧД 11-р хороо Нуур 22-506	99100813
	ЧД 18-р хороо 1-р буудал	99207680, 99408617
	ЧД 11-р хороо Нуур 21-465	88709002
	ЧД 15-р хороо Хайлааст	88180835
	ЧД 15-р хороо	88112964
ХУД	ХУД 3-р хороо Дунд Гол 5-р гудамж	88165252
	ХУД 9-р хороо Буянт-Ухаа 22А-1	99170022, 99071950
	ХУД 7-р хороо Жаргалант 10-132	80747898
НД	Налайх 8-р хороо 2-16А	88080373
	Налайх 7-р хороо Өвөр Сант 17-12	88155364
	Налайх 3-р хороо Дэнж агуулах	88080373, 89575765
	Налайх 3-р хороо Дэнж 21-4	99290303

БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ БҮТЭЭГДЭХҮҮН ХУДАЛДААЛДАГ ДЭЛГҮҮРҮҮД



ЦОМХОН ЭКО ДЭЛГҮҮР

TSONHON ECO SHOP

/хуруу зай цэнэглэгч, аяга
таваг угаагч, бие угаагч,
хулсан сойз, даавуун тор/

☎ 8017 5560

f [fb.com/tsomhon](https://www.facebook.com/tsomhon)

ГУА ШОП:

/Хулсан бүтээгдэхүүнүүд,
эко аяга таваг угаагч,
хатуу савангууд, аяны
халбага сэрээ, савнууд/

☎ 9919 1093

f [fb.com/gua.shopping](https://www.facebook.com/gua.shopping)

МИНИ ШИЙДЭЛ | MINI SOLUTIONS

☎ 7272 6000

f [fb.com/minishiidel](https://www.facebook.com/minishiidel)

ECOSY

/Хулсан бүтээгдэхүүнүүд, эко аяга
таваг угаагч, аяллын гал тогооны
хэрэгслүүд, эмэгтэйчүүдийн
ариун цэврийн аяга/

☎ 9900 8448

f [fb.com/ecosy.mongolia.9](https://www.facebook.com/ecosy.mongolia.9)

3E ECO SHOP MONGOLIA

/лаа, хулсан бүтээгдэхүүнүүд,
шүдний оо, ванны давс, органик
саван шампунь/

☎ 8611 8622

f [fb.com/3EShopMongolia](https://www.facebook.com/3EShopMongolia)

ЭКО ХУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН

☎ 8892 4976

f [fb.com/profile.php?id=100057581763824](https://www.facebook.com/profile.php?id=100057581763824)

ГЭР ОРГАНИК ДЭЛГҮҮР

GER ORGANIC STORE

/байгальд ээлтэй бүтээгдэхүүнүүд/

☎ 7509 9119

f [fb.com/gerorganicstore](https://www.facebook.com/gerorganicstore)

ХУЛС ШОП

/аяллын эко бүтээгдэхүүн/

☎ 9455 0150

f [fb.com/bamboo.shop13](https://www.facebook.com/bamboo.shop13)

ECO LIFE MONGOLIA

/байгальд ээлтэй бүтээгдэхүүнүүд/

☎ 7277 1177

f [fb.com/zerowastemongol](https://www.facebook.com/zerowastemongol)

ECO MON

/эко гоо сайхны бүтээгдэхүүн/

☎ 7277 1177

f [fb.com/ECO-MON-107572588474815](https://www.facebook.com/ECO-MON-107572588474815)

ЭКО МУХЛАГ ОНЛАЙН ДЭЛГҮҮР

/байгальд ээлтэй бүтээгдэхүүнүүд/

☎ 9914 8892

f [fb.com/ecomukhlag](https://www.facebook.com/ecomukhlag)

LHAMOUR

/байгалийн гаралтай гоо
сайхны бүтээгдэхүүнүүд/

☎ 7712 0256

f [fb.com/lhamourskincare](https://www.facebook.com/lhamourskincare)

ECO TIPS ESHOP

/байгальд ээлтэй
бүтээгдэхүүнүүд/

☎ 8804 7486

f fb.com/Eco-tips-eshop-113407883863328

SIMPLENESS

/байгальд ээлтэй
бүтээгдэхүүнүүд/

☎ 9973 4300

f fb.com/simpleness.eco

ECO BAR MONGOLIA

/байгальд ээлтэй
бүтээгдэхүүнүүд/

☎ -

f fb.com/eco.bar.mongolia

LAPERLA-MONGOLIANPRODUCTS

/байгальд ээлтэй
бүтээгдэхүүнүүд/

☎ 9955 2227

f fb.com/laperlamongolia

BADAMIN BRAND MONGOLIA

/хатуу үс арчилгааны
бүтээгдэхүүнүүд/

☎ 7766 0777

f fb.com/Badamin-Brand-Mongolia-1861008914187403t

NOMADIC BEAUTY

/байгалийн гаралтай үс, бие
арчилгааны бүтээгдэхүүнүүд/

☎ 7715 6833

f fb.com/info.nomadicbeauty

GOO BRAND

/олон нэр төрлийн органик гоо
сайхны бүтээгдэхүүнүүд/

☎ 7777 7755

f fb.com/GooCosmetics

ЦОМХОН ЭКО ДЭЛГҮҮР

/байгальд ээлтэй
бүтээгдэхүүнүүд/

☎ 8017 5560

🌐 tsomhon.mn/products/17563

ЦЭГЦ ДААВУУН ТОР

/хэвлэлттэй даавуун торнууд/

☎ 8895 1669

f fb.com/HevleltteiDaavuunTor

ДААВУУН ТОР

/Сав баглаа боодол/

☎ 7600 1919

f fb.com/uutmn

BABY PANDA MONGOLIA

/Угаадаг эко живх/

☎ 8989 1242

f fb.com/babypandamn



ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР, ААН-ҮҮД

Од пластик ХХК

Бүтээгдэхүүн:

- HDPE үрэл
- Хогны уут



Хэв хашмал хуванцар ХХК

Бүтээгдэхүүн:

- PP, PE үрэл
- Барилгын хэв хашмал
- Гэр ахуйн бараа
- Сувинер



Ансэхэ ХХК

Бүтээгдэхүүн:

- Цахилгааны хамгаалалтын хоолой
- HDPE



Сэртэн хангай ХХК

Бүтээгдэхүүн:


- HDPE үрэл
- Хогны уут



Метро пласт ХХК

Бүтээгдэхүүн:

- Вакум цонх,
- Цэвэр, бохир усны хоолой



Сан-Оргиу ХХК

Бүтээгдэхүүн:


- Сандал
- Траншейний таг
- Подон
- Хайс
- Шон



Идэр ивээлт ХХК

Бүтээгдэхүүн:

- HDPE үрэл
- Хогны уут



Пластик центр ХХК

Бүтээгдэхүүн:

- Нүхэн жорлонгийн сав
- Шилжүүлэгч таг
- Траншейний таг
- Бүх төрлийн цутгамал хуванцар



Тэр Их Нуур ХХК

Бүтээгдэхүүн:

- Бохирын болон усны хоолой



Ти Эм Эл ХХК

Бүтээгдэхүүн:

- Импорт орлох PET
- Хуруу шилэн бэлдэц



Мултипак ХХК

Бүтээгдэхүүн:

- Багцлагч уут
- Пакет



Сод Түм ХХК

Бүтээгдэхүүн:

- Цахилгааны хамгаалалтын хоолой
- HDPE



Түмэн эгшиг ХХК

Бүтээгдэхүүн:

- Барилгын материалын хагас бэлдэц



ОБ Пластик ХХК

Бүтээгдэхүүн:

- Гялгар уут хэвлэлтэй
- Багцлагч уут
- Сав баглаа боодол



Цэцүүх Трэйд ХХК

Бүтээгдэхүүн:

- Хуванцар үрлэн түүхий эд



Грийн пластик УБ ХХК

Бүтээгдэхүүн:

- Хогны уут, сав баглаа боодол



Инахис ХХК

Бүтээгдэхүүн:

- Резинэн хавтан



Пийс стийл групп ХХК

Бүтээгдэхүүн:

- Усан онгоцны жин тэнцвэржүүлэгч



МСРТ ХХК

Бүтээгдэхүүн:


- Шорлогны түлш



Хай би ойл ХХК

Бүтээгдэхүүн:

- Моторын масло
- М-100 мазут



Мон Пити Ойл ХХК

Бүтээгдэхүүн:

- М-100 мазут



Ногоон газар трейдинг” ХХК

Бүтээгдэхүүн:

- Полистрол хавтан, блок



Эко Тайхи ХХК

Бүтээгдэхүүн:

- Компост бордоо



Ти Жэй Эн Ресайклин ХХК

Бүтээгдэхүүн:

- Компост бордоо



Үлэмж Хүдэр ХХК

Бүтээгдэхүүн:

- Хар тугалган
гулдмай



“Алтан Оршихуй групп” ХХК

Бүтээгдэхүүн:

- Дизель түлш
- М-100 мазут



ЗАРИМ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД, ОЛОН НИЙТИЙН БҮЛГҮҮДИЙН СОШИАЛ ХОЛБООСУУД

КАРИТАС ЧЕХ РЕПАБЛИК ОУТБЪ:

- ☎ 7013 5899
- f fb.com/CaritasCzechRepublicInMongolia

ЭКОСУМ ТББ:

- ☎ 8014 2043
- f fb.com/Ecosoum

МОНГОЛЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОЛБОО:

- ☎ 8911 6570
- f fb.com/MongolianNationalRecyclingAssociation

МОНГОЛЫН ХУВАНЦАР ДАХИН БОЛОВСРУУЛАГЧДЫН ХОЛБОО:

- ☎ 9982 3222

МОНГОЛЫН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ХОЛБОО:

- ☎ 7017 3099, 7017 0399
- t twitter.com/monhazardous
- f Аюултай Хог Хаягдлын Холбоо

ӨНГӨ НЭМ ТББ:

- ☎ 9900 2058
- f fb.com/ungunem

ХОГГҮЙ МОНГОЛ ТББ:

- ☎ 9510 4373
- f fb.com/NoPlasticMongolia

НОГООН СЭТГЭЕ КЛУБ:

- ☎ 8088 1308
- f fb.com/ThinkGreenMongolia

ХОГОО БАГАСГАЯ БҮЛГЭМ:

- f fb.com/groups/2127875217449095

ХОГОО АНГИЛЬЯ БҮЛГЭМ:

- f fb.com/groups/hogooangiljungunem

ZERO WASTE MONGOLIA:

 9501 6555

 fb.com/ZeroWasteMGL


ZERO WASTE CLUB:

 9983 3629

 fb.com/Zerowasteclubmn

ХОГОО ЭХ ҮҮСВЭР ДЭЭР НЬ АНГИЛЖ ХЭВШЬЕ:

 7000 2444

 fb.com/groups/1651914868202992


3R4UB:

 fb.com/3R4UB

УЛААНБААТАР ХОТЫН АХУЙН ХОГ ХАЯГДЛЫН ЦУГЛУУЛАЛТ, ТЭЭВЭРЛЭЛТИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСӨЛ:

 7011 1220

 fb.com/Эерэг-давалгаа-UB-waste-111263011238817

 www.waste.ub.gov.mn

ZERO TO HERO

 8966 1565


 fb.com/zero2heroez

БИД БОЛ ДЭЛХИЙ - ХҮМҮҮС

 fb.com/WeAreTheEarthmen


БИ БОЛ ДЭЛХИЙ - ХҮН

 8976 8466

 fb.com/EarthmanBook



МОНГОЛЫН
ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН
ГҮҮР ТББ

 Монгол улс, Улаанбаатар-15170, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Аризона оффис төв, 35 тоот

 zwm.msdb@gmail.com
contact@plastic-recycling.mn

 +976 9501 6555; +976 9502 3489; +976 9503 3489

 fb.com/MongolianSustainableDevelopmentBridge

 instagram.com/isustainable_mongol

 twitter.com/isustainable_m

 www.plastic-recycling.mn